



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/642

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын 7 дугаар цэцэрлэгийн дулааны шугам засварлах зардалд 3364000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардал 3364000 төгрөг /Гурван сая гурван зуун жаран дөрвөн мянга/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.11 дэх "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



Zax A/642 Ch

02 03165

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 08-ны өдрийн
А/642 дугаар захирамжийн хавсралт



7 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ДУЛААНЫ
ШУГАМ ЗАСВАРЛАХ ЗАРДАЛ

дд	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Турбо /80-ын голчтой/	м	80 м	18000	1440000
2	Отвод	ш	8	8000	64000
3	Хаалт	ш	2	130000	260000
4	Гагнуур			1000000	1000000
5	Эксоватр	м	40	15000	600000
	Дүн				3364000

--oOo--